

**ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
10 ДУГААР АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН АНГИ
ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР**

Хугацаа-60 минут

А ХУВИЛБАР

Нийт оноо-40

Анги :

Сурагчийн нэр :

Аалзны хорвоо

Мухар цагаан ямаа яаж элсэн дээр уруугаа харсан юулүүр шиг шувтан нүх гаргаж чадах вэ? Гэвч манай нутгийн тэр гайхал мухар цагаан ямаа шилэн саванд шингэн бодис юулдэг гоожууртай ав адилхан шувтан нүхийг элсэн дотор гаргаж чаддаг байлаа. Түмэн бодис заадаг багшийн шилэн юулүүртэй адилхан элсэн нүх бүтээхдээ нэг ч ширхэг элс доошоо гулгахааргүй цэвэрхэн ажиллана. Тэрхүү шувтан нүхнийхээ ёроолд Мухар цагаан ямаа тухтай хэвтэж “Зочноо” хүлээнэ. Шувтан нүхний дээд ирмэг нь цалгар өргөн, доошлох тутам нарийssaар ёроолдоо зөвхөн мухар цагаан ямаа өөрөө багтас төдий уйтсан болно. Тэрхүү элсэн барилгын дээд хөвөөгөөр явж байгаа амьтан өчүүхэн төдий хазгай гишгэвэл шувтан нүхний хана даган тортон элстэй хамт ёроолд нь урсан хүрнэ. Тэр үед мухар цагаан ямаа нөгөөх амьтныг дороос нь зулгаан идэж гарна. Хазуулсан амьтан зугтах гэж дээш тэмүүлэвч дээшлэх тусмаа өргөссөн нүхний налуу ханын элс нурж буцаад л ёроолд хүрнэ. Тэр хооронд мухар цагаан ямаа түрүүн хазаж авснаа идэж, сорж дуусаад амаа ангайн хүлээж байна. “Зочныг” дахин өнхөрч орж ирэхэд дороос нь дахиад л хазаад авна. Ингэснээр байгаад “зочноо” дуустал зооглож орхино. Дараа нь “зочныхоо” хөлд нурсан гэрийнхээ элсэн ханыг нүд ирмэх зуур засчхаад ёроолд нь амран хүлээнэ. Ийм л айхтар мухар цагаан ямаа байдаг юм. Тэр маань ердөө л шалзан чинээ аалз шүү дээ! Аалз бүхэн шүлсээрээ тор нэхдэг байтал мухар цагаан ямаа элсээр юулүүр хийгээд ёроолд нь ангайн хүлээж хорхой шавжийг ховдог хodoод руугаа юулдэг амьтан. Бие нь өчүүхэн мөртлөө амьдрах аргаараа том энэ амьтан дэлхий дээрх 50 мянган төрөл зүйл аалзны нэг нь гэхдээ элсээр урхи, тор хийдгийн хувьд тэр олны дундаас онцгой юм. Аалзнаас зэвүүцдэггүй хүнийг хaa ч үзсэнгүй. Цөм л аиж, бишүүрхэж аалзыг хaa яваа газар нь няц дараахыг эрмэлзэнэ. Хүний дэргэд аалз өчүүхэн амьтан боловч хүмүүс түүнээс яагаад айдаг вэ? ... Эсвэл хүнийг адгусны ертөнцөөс тасраагүй шахам балчир ахуйд нь эдгээр амьтад хөнөөл учруулсан тэр нь уураг тархинд бичигдэн үлдээд уламжилсан айдас мөнхөрсөн юм уу? Тийм ч байж болно. Учир нь энэ ... амьтан хуурай газраа “ахмад настнууд”, идэр залуудаа аюултай ч байсан байж болно. Аалз гэхэд дөрвөн зуун сая жилийн урт зам туулжээ. **Аалзны зарим нууцыг хүн одоо болтол нээж чадаагүй байна. Нэхсэн төрон дээгүүрээ маш хурдан гүйдэг мөртөө арвагар олон хөл нь төрөндоо яагаад орооцолддоггүй мэдэж амжаагүй байна.** Тор нэхэх шүлс нь өчүүхэн булчирхайнаас яагаад тийм их хэмжээгээр нэг дор гарч чадаж байгаа хэрэг вэ? Дэлхийн бүх аалз алга болчихвол ямар гэм хор учрах вэ? Олон асуултад аалз хариу өгөх дургүй байна. ... хөдөлмөрийн багаж зэвсэг нь нэн боловсронгуй ажээ. Маш нарийн зохион байгуулалттай тор эсвэл нүх, урхи бас аргамж, цалмаар хүртэл ан хийдэг аалз бий. Арваалж, цагаан тэмээ, хар, шар аалзнууд бол “химиийн” буюу бактерлогийн зэвсэгтэй юм. Аалзны нууцыг үйлдвэрлэл, аж ахуйд хэрэглэхийг хүн оролдож байлаа. Гэвч ирээдүйн сансар судлалд аалз их юм өгч магадгүй амьтан юм. Муухай царайлж байгаад их нууцтай амьтан шүү, аалз! Л. ТҮДЭВ

1. Тодруулсан үгийн утгыг хам сэдвийн хүрээнд тайлбарлана уу? \4 оноо

Урхи бас аргамж, цалмаар ан хийдэг:

Нүд ирмэх зуур :

2. Эхэд ашигласан баримт бүхий өгүүлбэрүүдээс ялгаж бичээрэй. \4 оноо

.....

.....

3. Тодруулсан хэсгээс алзны чадварыг гайхах зохиогчийн сэтгэлийн өнгө аяс илэрсэн 4 өгүүлбэрийг олж бичээрэй. \4 оноо

4. Учир нь энэ ... амьтан хуурай газраа “ахмад настнууд”, “идэр залуудаа аюултай ч байсан байж болно” гэсэн өгүүлбэрт цуваа цэг хэрэглэсний учир юу вэ? \2 оноо

A. Өгүүлбэрийн дунд хэлэлгүй орхисон үгийн оронд цуваа цэг хэрэглэсэн.

B. Мэгдэж түгдэrsэн тул цуваа цэг хэрэглэсэн

C. Үг, өгүүлбэр төгссөн боловч зохиогч санаагаа бүрэн гаргаж чадаагүй.

D. Зохиолын том бүлэг, их хэсгийг орхисон тул мөрлөсөн цэг хэрэглэсэн.

5. Дараах алдаатай өгүүлбэрийг зөв болгон бичнэ үү? \2 оноо

Галт уул урсаж, дэлбэрэн, уруудан, оргилж, үүсгэжээ

6. Монголын нууц товчооны 1-р бүлэгт Тэмүжиний бага насны талаар хэрхэн ойлгосноо 40-50 үгэнд багтаан бичнэ үү? \5 оноо

.....

.....

.....

.....

.....

.....

7. Д. Намсрай “Жамухын өчил” өгүүллэгт юуны тухай гардаг вэ? Анд, нөхөрлөл гэж юу вэ? \2 оноо\

.....

.....

.....

.....

.....

.....

8. Д.Нацагдорж “Ламбагуайн нулимс” өгүүллэгийн унших явцад зохиолын аль илүү таалагдсан бэ? Жишээгээр тайлбарлан бичнэ үү? \2 оноо\

.....

.....

.....

9. Дараах өгүүлбэрийг уншаад кирил бичигт хөрвүүлээрэй. \5 оноо\

بىشىم ئەنلىقەن ئەنلىقەن ئەنلىقەن ئەنلىقەن	ئەنلىقەن ئەنلىقەن ئەنلىقەن ئەنلىقەن ئەنلىقەن
ئەنلىقەن ئەنلىقەن ئەنلىقەن ئەنلىقەن ئەنلىقەن	ئەنلىقەن ئەنلىقەن ئەنلىقەن ئەنلىقەن ئەنلىقەن
ئەنلىقەن ئەنلىقەن ئەنلىقەن ئەنلىقەن ئەنلىقەن	ئەنلىقەن ئەنلىقەن ئەنلىقەن ئەنلىقەن ئەنلىقەن
ئەنلىقەن ئەنلىقەن ئەنلىقەن ئەنلىقەن ئەنلىقەن	ئەنلىقەن ئەنلىقەن ئەنلىقەن ئەنلىقەن ئەنلىقەن
ئەنلىقەن ئەنلىقەن ئەنلىقەن ئەنلىقەن ئەنلىقەن	ئەنلىقەن ئەنلىقەن ئەنلىقەن ئەنلىقەن ئەنلىقەن

.....

.....

.....

.....

.....

.....

ХОЁРДУГААР ХЭСЭГ:

10. Өөрийн хамгийн сайн мэдэх амьтны тухай тайбарламж эх зохион бичээрэй..
(Бичихдээ бүтэц, хэв шинж, сэдэв, агуулгын харьцаа болон найруулга зүйн шаардлагыг сайтар тооцоолж, баримт мэдээлэл болон дүрслэх ур маягийг зохистой ашиглаарай.)
Бичгийн соёл оноонд нөлөөлөх тул хичээнгүй, гаргацтай бичээрэй. /Үгийн тоо 180-200\

\10 ohool

**ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
10 ДУГААР АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН АНГИ
ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР**

Хугацаа:60 минут

Б ХУВИЛБАР

Нийт оноо: 40

Анги :

Сурагчийн нэр :

Монгол толбо

Залуухан сувилагч бүсгүй нүд нь орой дээрээ гарчихсан гүйж ирээд их л гэмшсэн байдалтайгаар нэг үг хэлэх гэснээ түгдрэн зогтусав. Манай ууган охин Москвагийн нэгэн төрөх тасагт мэндлээд хэдхэн хоног болж байсан цаг л даа.

- Охин зүгээр биз! гэж сандран асуувал сувилагч бүсгүй толгой сэгсрэн
- Ууцан дээр нь алга дарам газар хөх няц болчож. Ойччихсон байх аа! Хэдүйд нь ойчдог юм бэ? Би ердөө санахгүй байна гэж хоолойгоо чичруүлэн хэлэв. Ууцан дээгүүрх “хөх няц” гэдэг нь ердөө л монгол хүүхэд бүрд байдаг төрөлхийн хөх толбо ажээ. Би инээдээ барьж ядан: -Хөх няц биш! Монгол хүүхэд нялхдаа ийм байдаг юм гэсэн чинь тэр итгэж ядан охиныг дахин манцуйлж эхлэв.Тэр цагаас эхэлж монгол толбоны тухай би эргэцүүлэн боддог болсон юм. Монгол хүнээс өөр хэн ч тийм хөх толботой төрдөггүй учраас дэлхийн анагаах ухаанд “Монгол толбо” гэж нэрлэгдсэн энэ үзэгдэл одоо хүртэл бүрэн тайлбарлагдаагүй байна. Монгол толботой хүмүүс дэлхийн өөр орон нутагт байдаг нь илэрхий болж бас гайхаш төрүүллээ. Мажаар хүмүүс дотор монгол толботой хүүхэд төрдөг ажээ. Тэр ч арга буюу монгол гаралтайгаа үзүүлж байгаа хэрэг юм. Хортобаажийн тал нутагт Ижил мөрнөөс нүүж очсон хүннү нарын удам угсаа учраас, арга буюу монгол толботой байгаа юм. Гэтэл алс тэртээ хойт Америкад бас “монгол толботой” хүмүүс байдаг нь ямар учир вэ?

“...намхан нуруутай, урт гартай, тавхай сарвуу богинотой боловч бусадтай харьцуулахад гавал томтой хүмүүс байжээ. Майя хүүхэд төрөхдөө “монгол толбо” гэгдсэн Дорнод Азийнханд байдаг тэмдэгтэй байх нь олонтаа. Энэ нь жижигхэн хөх толбо бөгөөд тийм гэх хэлбэргүй, ууцны төгсгөл хавьцаа байдаг тэгээд арван насанд арилдаг” гэж эртний соёл судлаач нэрт эрдэмтэн Сильванце Морли бичжээ. “Америкийн индейчүүдийн шууд өвөг нь Байгаль орчмоор аж төрж байсан шинэ чулуун зэвсгийн үеийн хүмүүс бөгөөд шошооныхон бол индейчүүдэд бүр ойр төрөл юм” гэж нэрт эрдэмтэн Алеш Ходлынхан бичжээ. Нэгэн зүйл.Майя нар өөрийн бичиг, үсэгтэй, зургаан оронтой тоогоор тооцоо хийдэг, асар өвөрмөц цац суврага барьж чаддаг, алт мөнгө эдэлдэг, өндөр соёлтой хүмүүс болтлоо өсөж хөгжжээ. Азид байхдаа үүнийг чаддаг үүнийг байгаагүй нь илэрхий. Гэхдээ чадах бэлтгэлээ хийчихсэн байж болно. Колумбын өмнөх индейчүүдийн Кечуа омгийнхон хүй нэгдлээ “айл” гэдэг байжээ.Энэ нь зүсээ огтхон ч хувилгаагүй монгол үг юм. Айл аймаг, айласах, буух гэдэг бидний үг маань “ай” гэсэн эхээс л цөм төрсөн юм.Үүнээс олон үг салбарлан төржээ. Индейчүүд монголчуудаас ганцхан үг хожим сураагүй нь тодорхой. Айл гэдэг бол ганц нэгээрээ амьдрахаас хэдий нь өнгөрөөд нийтээрээ, хамт олноороо аж төрөх болсон үеийн нэр. Индейчүүд тэгэхээрээ Азид байхдаа хүний зохион байгуулалттай хамтлаг болчихсон байжээ. Айл гэдэг үгийг “аалы”, “аул”, “аил” гэх мэтээр нутгийн аялга оруулаад одоо хүртэл дунд Ази, Кавказ, Тундр хүртэлх өргөн дайдад суугчид хэрэглэсээр байна.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: УНШИЖ ЧАДВАР СОРЬСОН ДААЛГАВАР :

1. Эхийн гол санааг илэрхийлсэн 40-50 үгэнд багтаан бичээрэй. \4 оноо

2. Өгүүлбэрийн тодруулсан үгсийг ойролцоо утгатай үгээр солин найруулж бичээрэй. \4 оноо

Монгол толботой хүмүүс дэлхийн **өөр** орон нутагт байдаг нь **илэрхий** болж бас гайхаш төрүүллээ.

-
-

3. Эхээс тайлбарлагдаж буй юм, тайлбарлаж буй хэсгийг ялган бичээрэй. \4 оноо

Тайлбарлагдаж буй юм

-

Тайлбарлаж буй байдал

-
-
-
-

4. Дараах өгүүлбэрийн найруулгын алдааг засаж бичээрэй. \2 оноо

Хот айлаас хонь идээшлэн бэлчсээр 100 гаруй метр явсаар үдийн өмнөх амралт болдог.

5. “Хүн нэрээ, тогос өдөө” гэсэн хэлц өгүүлбэрийн найруулгын утгыг тайлбарлан бичээрэй. \2 оноо

6. “Бодончар Богд” зохиолын гол утга санааг 40-50 үгэнд багтаан өөрийн бодлоор бичээрэй. \5 оноо

.....

.....

.....

.....

.....

.....

.....

7. Жамухын дүрийг зохиолд хэрхэн дүрслэгдсэн бэ? Тайлбарлан бичээрэй. \2 оноо\

.....

.....

.....

.....

.....

.....

8. Д.Нацагдорж “Хөдөө талын үзэсгэлэн” зохиолд морины байдлыг яаж дүрсэлсэн бэ? Төсөөлөн бичээрэй. \2 оноо\

.....

.....


.....

.....

.....

.....

9. Эхийг уншаад кирил бичигт хөрвүүлээрэй. \5 оноо\



.....

.....

.....

.....

.....

.....

.....

Өөрийн хамгийн сайн мэдэх ургамлын тухай тайбарламж эх зохион бичээрэй..
(Бичихдээ бүтэц, хэв шинж, сэдэв, агуулгын харьцаа болон найруулга зүйн шаардлагыг
сайтар тооцоолж, баримт мэдээлэл болон дүрслэх ур маягийг зохистой ашиглаарай.)
Бичгийн соёл оноонд нөлөөлөх тул хичээнгүй, гаргацтай бичээрэй. /Үгийн тоо 180-200/

\10 ohooh

Х АНГИЙН АНГИ ДЭВШИХ МОНГОЛ ХЭЛ, БИЧГИЙН ХИЧЭЭЛИЙН ШАЛГАЛТЫН ТҮЛХҮҮР

А ХУВИЛБАР

1. Урхи бас аргамж, цалмаар ан хийдэг гэдэг нь арга ухаан гаргаж ан авладаг, нүд ирмэх зуур маш хурдан болж өнгөрөх тайлбарласан бол 4 оноо, 1-ийг тайлбарласан бол 2 оноо
2. Эхээс хоёр баримт олсон бол 4 оноо, нэг баримт бичвэл 2 оноо
3. 4 өгүүлбэр бичсэн бол 4 оноо, 3 өгүүлбэр бичсэн бол 3, 2 өгүүлбэр бичсэн бол 2 оноо, 1 өгүүлбэр бичсэн бол 1 оноо
4. А. Өгүүлбэрийн дунд хэлэлгүй орхисон үгийн оронд цуваа цэг хэрэглэсэн гэж сонговол-2 оноо
5. Өгүүлбэрийг зөв байрлуулан, бичсэн бол 2 оноо, дөхүүлсэн бол 1 оноо
6. Хариултыг бүрэн хариулсан бол 5 оноо, дөхүүлсэн бол 3 оноо
7. Хариултыг бүрэн хариулсан бол 2 оноо, дөхүүлсэн бол 1 оноо
8. Хариултыг бүрэн хариулсан бол 2 оноо, дөхүүлсэн бол 1 оноо
9. Монгол бичгийн даалгавар үгийн тоо-25
 - 0-1 алдвал 5 оноо
 - 2-4 алдвал 4 оно
 - 5-7 алдвал 3 оноо
 - 8-10 алдвал 2 оноо
 - 11-13 алдвал 1 оноо
 - 14 дээш алдвал 0 оноо

Агуу хүч бага боловч ухаан билиг сайн болвоос

Асар хүчит дайсанд ч үл дийлд юу

Араатны хаан хүчит цагаан арсланг

Аргат өчүүхэн туулай хуураад алсан үлгэр

10. Эх зохион шалгуур:

Үндэсплэл-1

Мэдээлэл баяжуулалт-2

Бичлэгийн хэлбэр-1

Бүтэц-1

Найруулга-1

Үгийн тоо-1

Зөв бичих дүрмийн алдаа-2

Бичгийн хэв-1

Х АНГИЙН АНГИ ДЭВШИХ МОНГОЛ ХЭЛ, БИЧГИЙН ХИЧЭЭЛИЙН ШАЛГАЛТЫН ТҮЛХҮҮР

Б ХУВИЛБАР

1. Монгол толбо түүний талаар санаагаа бүрэн гаргасан тайлбарласан бол 4 оноо, дөхүүлж тайлбарласан бол 2 оноо
- 2. ондоо, тодорхой** гэж засаж бичсэн бол 4оноо, нэг жишээ бичвэл 2 оноо
3. Тайлбарлагдаж буй юм: Монгол толбо, Тайлбарлаж буй байдал жишээ бичвэл- 4оноо, нэгийн хийвэл 2оноо
4. Хот айлаас 100м гаруй метр яваад хонь идээшлэн бэлчсээр үдийн өмнөх амралт болдог гэж бичсэн бол – 2 оноо, дөхүүлбэл 1 оноо
5. Холбоо үгийн утгыг бүрэн бичсэн бол 2 оноо, дөхүүлсэн бол 1 оноо
6. Хариултыг бүрэн хариулсан бол 5 оноо, дөхүүлсэн бол 3 оноо
7. Хариултыг бүрэн хариулсан бол 2 оноо, дөхүүлсэн бол 1 оноо
8. Хариултыг бүрэн хариулсан бол 2 оноо, дөхүүлсэн бол 1 оноо
9. Монгол бичгийн даалгавар үгийн тоо-22
 - 0-1 алдвал 5 оноо
 - 2-4 алдвал 4 оно
 - 5-7 алдвал 3 оноо
 - 8-10 алдвал 2 оноо
 - 11-13 алдвал 1 оноо
 - 14 дээш алдвал 0 оноо

Хоёулаа Наху баяны гэрт хүрвэл, хөвгүүнээ алдав гэж нус нулимс болж байсан Наху баян хөвгүүнээ ирснийг үзээд нэг уйлж, нэг загнаж үзэв.

10. Эх зохион шалгуур:

Үндэслэл-1
Мэдээлэл баяжуулалт-2
Бичлэгийн хэлбэр-1
Бүтэц-1
Найруулга-1
Үгийн тоо-1
Зөв бичих дүрмийн алдаа-2
Бичгийн хэв-1